

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-17

-
- 1. Төрийн аудитын байгууллагын 2024 оны төсвийн төсөл* 5-7

 - 2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 7-12

 - 3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 13

 - 4. Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт* 13-17

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
06 дугаар сарын 21-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 23 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баделхан, С.Ганбаатар, Б.Жавхлан, Ц.Сандаг-Очир;

Чөлөөтэй: С.Одонтуяа;

Тасалсан: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Ч.Хүрэлбаатар.

Нэг.Төрийн аудитын байгууллагын 2024 оны төсвийн төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Тамгын дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр, мөн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Захиргаа, хууль, эрх зүйн газрын санхүүгийн менежер, Ерөнхий санхүүч П.Батцэцэг, Мэдээллийн технологийн төвийн мэдээллийн технологийн менежер А.Уянга-Эрдэнэ, нягтлан бодогч Б.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төрийн аудитын байгууллагын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Үндэсний аудитын газрын 2024 оны төсвийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч П.Товуудорж, мөн хорооны Үнэ тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтийн талаар Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Батжаргал, Г.Амартүвшин нар үг хэлэв.

Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийн асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн Б.Пүрэвдорж ажлын 1 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав. /11:11/

Уг асуудлыг 11 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 48 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 23 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр Байнгын хорооны хуралдаанд Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн байна.

Та бүхэнд хуралдаанд оролцож байгаа гишүүдийн нэрсийг танилцуулъя. Ганибалын Амартүвшин, Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа, Цэрэнпиллийн Даваасүрэн, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд, Дуламдоржийн Тогтохсүрэн, Баттогтохын Чойжилсүрэн нар хүрэлцэн ирснээр Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Төрийн аудитын байгууллагын 2024 оны төсвийн төсөл.

Хоёрт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг.

Хоёрт, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Дөрөвт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт гэсэн ийм саналтай байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээр асуудал. Төрийн аудитын байгууллагын 2024 оны төсвийн төслийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. Занданбат даргын микрофоныг өгье. Номер 3.

Д.Занданбат: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Төрийн аудитын байгууллагын 2024 оны төсвийн төслийг боловсруулж Төрийн аудитын тухай хуулийн 40.2, 40.5-д заасны дагуу тус Байнгын хороонд хянуулахаар хүргүүлсэн Төсвийн төслийг хураангуйлан танилцуулъя.

Төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэлд суурилсан, үр дүнд чиглэсэн төлөвлөлт, төсөвлөлттэй байх зорилтыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” зэрэг хөгжлийн хөтөлбөрүүдэд тусгасан.

Төрийн аудитын байгууллага нь аудитын үйл ажиллагааг үр дүнд чиглүүлэн төсвийн үр ашигтай байдлыг бий болгох дараах чиглэлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн төсөлтэй хамтран ажиллаж байна.

1.Төрийн аудитын байгууллагын албан хаагчдыг үр дүнд суурилсан төлөвлөлт болон төсөвлөлтийн арга зүйд суралцуулах, чадавхжуулах.

2.Төрийн аудитын үйл ажиллагааг үр дүнд чиглүүлэн 2024 оны төлөвлөлт, төсөвлөлтийг хийх.

3.Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэхдээ төсөв захирагчдын төсвийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэл, төсвийн тайлагнал, үр дүнд суурилсан арга зүйг хэрэгжүүлж чадаж байгаа эсэхэд дүгнэлт, зөвлөмж өгөх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагын 2024 оны бодлогын тэргүүлэх чиглэлийг тогтоохдоо дараах баримт бичгүүдийг үндэслэв.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа-2050”, Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги, Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын 2023-2028 оны стратеги төлөвлөгөө, аудитын дээд байгууллагын гүйцэтгэлийн хэмжүүрийн хүрээ, хэрэгжилтийн 2023-2028 оны стратеги, баримт бичгүүдэд үндэслэж тогтоов.

Төрийн аудитын өнөөгийн нөхцөл, байдлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийж улмаар дээрх баримт, бичгүүдийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлж болох Төрийн аудитын бодлогын зорилт, тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна.

1.Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг нэмэгдүүлнэ.

2.Төрийн аудитын байгууллагын хараат бус байдалд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ.

3.Төрийн аудитын байгууллагын чадамжийн үнэлгээг нэмэгдүүлнэ. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-д 1 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн баримт, бичгийн шаардлагын дагуу Төрийн аудитын байгууллагын 2024 оны төлөвлөгөөний

төсөлд 3 тэргүүлэх чиглэл, 8 үндсэн үйл ажиллагаа, 10 арга хэмжээ, 1 төсөлд нийтдээ 38.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөн тусгалаа.

Санхүүжилт өмнөх оноос 9 тэрбум 337.1 сая төгрөгөөр өсөхөд дараах зардлууд голлон нөлөө үзүүлж байна. Үүнд:

Төрийн албан хаагчдын цалин, хөлсний шинэчлэлтэй уялдуулан тооцоолсон дүнгээр цалин, хөлс болон нэмэгдэл урамишуулал ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн дүн 7 тэрбум 242.5 сая төгрөг, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх буюу албан хаагчдын чадамжийг дээшлүүлэх 789.1 сая төгрөг, мэдээллийн технологийн зардал, төрийн аудитын байгууллагын мэдээллийн ил тод байдал, цахим шилжилтийг сайжруулахад 214.5 сая төгрөг, урсгал сэлжүүлэг 512.7 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагын 2024 оны төсвийн төслийг хянан дэмжин шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Занданбат даргад баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор, Содномцэрэнгийн Цэрэнбаяр Үндэсний аудитын газрын Тамгын дарга, тэргүүлэх аудитор, Буянтогтохын Бундхорол Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Ядамын Самбууням

Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор, Пүрэвдоржийн Батцэцэг Захиргаа, хууль, эрх зүйн газрын санхүүгийн менежер, Ерөнхий санхүүч, Арсланбаатарын Уянга-Эрдэнэ Мэдээллийн технологийн төвийн мэдээллийн технологийн менежер, Батболдын Цолмон Үндэсний аудитын газар нягтлан бодогч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Раднаасэд гишүүнээр тасаллаа. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: 24 онд их л олон ажил хийх юм байна. Худлаа дүгнэлт гаргаж, эс үгүй бол гаргасан дүгнэлтээ засдаг байдлаа болиорой Занданбат даргаа. Энэ хараат бус байдлаа 2 хувиар нэмэгдүүлнэ, иргэдэд итгэх итгэлийг 2 хувиар нэмэгдүүлнэ гэж та нарын гарын үсгийн ард энэ итгэл чинь явж байгаа шүү. Тэр Алтайн, Улиастайн асуудлыг би дахиад анхааруулж хэлж байна шүү. Одоо тэр ажлаас нь чөлөөлсөн сайд нь энэ хажууд сууж байна. Танай дүгнэлтийг үндэслэж ажилгүй болгосон.

Тэгээд энэ байдлаар дахиж ийм алдаа дахиж гаргав. Энэ олон газар, олон юман дээр давтагдах юм бол энэний цаана асар их хорттой үр дагавар явна шүү. Та нар төрийн нүд, чих болж яваа байгууллагуудын нэг. Танай байгууллагын дүгнэлт үнэн байж байж энэ Монгол Улсын төсөв, төртэй холбоотой үйл ажиллагааны зардал, орлогын үнэн, зөв байдал баталгаажих ёстой.

Та нар зүгээр байгууллагын дотоод санхүүгийн хяналт биш, тайлан баланс дээр дүгнэлт гаргадаг албан ёсны эрх бүхий ганц байгууллага Монгол Улсын Их Хурлын дэргэд энэ хууль тогтоох байгууллагыг үнэн, зөв мэдээллээр хангаж байх ёстой ганц байгууллага. Жижиг сажгаар ингээд гаргаад ирсэн дүгнэлтүүдээ өдөрт нь өөрчилдөг, өдөрт нь гарчгийг нь сольдог энэ байдалд чинь

та нарт итгэх биш, бүүр итгэлийг чинь итгэх хүнгүй болно шүү гэдгийг би бүүр зориуд хэлж байна шүү.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн санал хэллээ. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд Үндэсний аудитын газрын 2024 оны төсвийн төслийг дэмжэе гэсэн томъёоллоор санал хураалгана. Гишүүд байраа эзлээрэй, санал хураалт. Санал хураалт.

Санал хураалт 72.7 хувиар дэмжигдлээ. Нийт санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжсэн байна.

Ингээд Төрийн аудитын байгууллагын 2024 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа. Эхний асуудал дууссан байна. Хоёр дахь асуудалдаа орё.

10.32 цаг

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд гишүүн хуулийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэж заасан байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай. Хоёр дахь асуудалтай холбогдуулж Аж ахуйн нэгжийн орлогын алан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Бямбарагчаагийн Тэлмүүн. Тэлмүүн дарга алга байна, Сангийн яам.

Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Зоригийн Мөнх-Оргил Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсандоржийн Мөнхжаргал Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга, Пүрэвжавын Товуудорж Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч, Базарвааны Эрдэнэбулган Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Микрофон, кнопоо дараарай. Өнөрболор гишүүнээр тасалъя. Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэндийг хүргэе. Тэмүүлэн гишүүн нэг зүйлийг асуумаар байна. Энэ асуултаа асуухаас өмнө байна шүү дээ энэ сая дэгийнхээ хуулиар сая ажлын хэсгийн дарга тайлбарлахдаа юу гэж хэлж байна гээд тэгэхлээр яг энэ хууль дээр бол зарчмын зөрүүтэй санал гаргах боломжгүй юм байна гээд тэгж байна л даа. Тэгэхлээр одоо яах ёстой вэ, яагаад боломжгүй байгаа вэ, энэ яагаад зарчмын зөрүүтэй санал гаргаж болохгүй гэсэн үг юм бэ. Болно биз дээ. Тэгээд яагаад болохгүй гэж тайлбарлаад яваад байгаа юм айн.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүний асуултад, сая нөгөө Өнөрболор гишүүн сая бичгээр сая саналаа ирүүлсэн байсан. Бид нар Байнгын хорооны ажлын албаныхнаар сая хянуулсан. Тэгээд зөвхөн Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиар зөвхөн хөндөгдсөн заалт дээр нэмэлт, өөрчлөлт оруулах, санал гаргах эрх бол нээлттэй байгаад байгаа юм.

Тэгэхээр нэг талдаа яг хөндөгдөөгүй заалт учраас таны гаргаж байгаа санал өөрөө нөгөө өргөн барьсан төсөлтэй уялдахгүй энэ заалтууд орж ирж байгаа гэсэн үг болчихож байгаа юм. Тэгэхээр энэ шинэчилсэн найруулга биш, нэмэлт өөрчлөлт учраас нэг талдаа хөндөгдөөгүй заалтууд дээр нэмэлт, өөрчлөлт оруулах гэдэг юм уу, нэмэх энэ боломж, бололцоо бол бас байхгүй байна. Дэгийн тухай хуулиараа хэлэлцэхдээ гарахыг хориглоно гэсэн заалт байгаад байгаа. 40.3.7 гэх заалт байгаа. Хуулийн төслийн заалтын үг, өгүүлбэрийн дараа бие даасан агуулга бүхий үг, өгүүлбэр нэмэх гэдгээр хориглоно гэсэн заалттай байгаад байгаа. Дэгийн тухай хуулиараа. Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Би шалтгаанаа бол энэний үрд гарах гэж байгаа үр дагаврын талаар би өшөө ахиад тайлбар, асуултаа бол авъя гэж бодож байгаа. Тэгээд ер нь бол сая би ингээд бичгээр энэ зарчмын зөрүүтэй саналынхаа томъёоллыг өгсөн байхгүй юу. Тэгэнгүүт энэ дээр бол энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн дараа тайлбар, тайлбар хэлбэрээр яг энэ хуулийн үйлдвэрлэх гэдэг энэ юун дээр, үйлдвэрлэх гэдэг энэ үгэн дээр нийслэл Улаанбаатар хотод түүхий нүүрс болон стандартын шаардлага хангаагүй түлшийг ашиглах тохиолдолд энэ заалт хамаарахгүй гэсэн гэж л нэмэх асуудал байж байгаа юм.

Тийм учраас бол энэ сая бид нар бас ярилцаад энэ болох боломжтой юм байна гэдэг асуудлыг бол ярилцлаа Тэмүүлэн дарга. Тэгээд би энэ яагаад энэ асуудал дээр юу яаж байна, дэмжихгүй байр суурьтай байгаад байгаа юм бэ гээд тэгэхлээр яг энэ Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ч байдаг юм уу, эсвэл энэ аж үйлдвэрийг, аж үйлдвэрийн сэргэлтийг дэмжих, Хөдөөгийн сэргэлт, Боомтын сэргэлт гээд энэ ажлын хүрээнд бол миний хувьд бол яг энэ бодлогын агуулгаар нь эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудал дээр бол дэмжиж байгаа. Тухайлах юм бол энэ Тавантолгойн 450 мегаватт, Багануур,

Бөөрөлжсүүтийн цахилгаан станцууд эд нар гээд байж байна шүү дээ тийм ээ. Дэмжихгүй байгаа нэг асуудал нь бол өнөөдөр энэ салбарын яам, сайд судалгаатай, шинжлэх ухаанчаар ард иргэдийнхээ эрүүл, аюулгүй байдлыг бол хангах эрхийг хангах ёстой байж байгаа энэ асуудлаар ялгамжтай оруулж ирэх шаардлагатай байгаа учраас би өнөөдөр энд зарчмын зөрүүтэй санал гаргасан юм.

Тэгээд ер нь энэ Эрчим хүчний яам иргэдийнхээ эрүүл, аюулгүй амьдрах орчны эсрэг агаарын бохирдлыг бууруулах бодлогоос бол ухарч байна өнөөг хүртэл тиймээ, 10 гаруй жилийн хугацаанд энэ агаарын бохирдол бол мөнхийн сэдэв байж ирсэн. Энэ дээр бол үнэхээр энэ Үндэсний хороо бол маш их эрчимтэй хэд хэдэн асуудлуудыг бол шат дараалан ингээд авч ирсэн. Энэнийхээ эсрэг бол Эрчим хүчний яам бодлого гаргаж байгаа учраас энийг бол дэмжихгүй байгаа юм.

Тэгээд энэ гоё танилцуулгын ард бол түүхий нүүрсээр ажиллаж байгаа энэ яндангуудыг ажиллуулах гэж байна. Өшөө ахиад нэмээд ажиллуулах гэж байна. Дээрээс нь нүүрс, зүгээр түүхий нүүрс түлэх гэж байна. Ийм бол байж болохгүй. Өнөөдөр дэлхий дээр эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх олон арга замууд байгаа. Тухайлах юм бол Net Zero стратегитай уялдуулахад бол дэвшилтэд технологийн ногоон санхүүжилт хийгээд маш олон арга замууд байж байгаа.

Тийм учраас энэ иргэдийн энэ эрүүл, аюулгүй байдлыг хангах асуудал маш чухал асуудал байж байгаа учраас хотод ялгамжтай байдлаар энэ зохицуулалтуудыг оруулж ирэх хэрэгтэй байгаа юм. Тийм учраас гишүүд та бүгдийг энэ зарчмын зөрүүтэй санал дээр, энэ тайлбар дээр дэмжихийг та бүгдээс хүсэж байна.

Тэгээд ийм хязгаарлалтыг ерөөсөө тавьж өгөхгүй бол өнөөдөр иргэдийн

аюулгүй энэ агаарын бохирдлын эсрэг авчирч ирсэн энэ арга хэмжээ бол үндсэндээ бол үнэ цэнгүйдэж ерөөсөө энэ бодлогын эсрэг ухрах нөхцөл байдал үүсэж байна.

Өчигдөр л гээд тэгэхэд чинь бид нар Байгаль орчны байнгын хороон дээр энэ олон улсын гэрээ, конвенцод Монгол Улс элссэн. Үүнийхээ дагуу бол хүлээж байгаа амлалт, үүргээсээ буцах ийм аюул учраад байгаа, эсвэл өчигдрийн тэр тайлбарлаж байгаагаар бол бид нар нүүрснээсээ салж чадахгүй юм байна. Зөвхөн нүүрснийхээ бодлогыг л авч явах юм байна гэх юм бол Эрчим хүчний яам тэрийгээ бол шууд зарлах хэрэгтэй. Хэрэв тийм ээ ингэх юм бол, хэрэв энэ бодлогоо авч явна гээд тэгэх юм бол зөвхөн нийслэлд ялгамжтай байдлаар тогтоох нь чухал асуудал болоод байна гэдгийг бол би хэлье.

Тийм учраас гишүүд та бүгдийг бас дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: Байнгын хорооны гишүүдийнхээ өглөөний амрыг эрье.

Өнөрболор гишүүнд ийм санал гаргаад байгаа юм. Урьд нь хэлэлцэх үед ч гаргасан. Хоёр тайлбар хэлье. Энэ хууль 2029 оны 12 сарын 31 хүртэл дагаж мөрдөгдөнө нэг.

Хоёрдугаарт энэ газад шилжихгүй бол бид нар нүүрсээ л түлэхээс ондоо арга байхгүй. Одоо боломжгүй юм ард түмэнд худлаа ярьж, амлахаа больё гэж бодож байгаа. Тийм учраас би өнгөрсөн долоо хоногт ОХУ-д ажиллаад ирлээ. Газпром нийгэмлэгийн даргын орлогчтой нь уулзлаа. Монголоор дамжуулаад тавигдах хийн хоолойн асуудлаар тодорхой хэмжээний мэдээлэл авлаа. ОХУ, Хятад Улс хоёр хоорондоо хэлэлцээ хийж байгаа юм байна. Хамгийн өөдрөгөөр төсөөлөх юм бол энэ ондоо

багтааж хийж магадгүй юм байна гэрээг. Тэгсэн тохиолдолд ирэх 2024 ондоо багтааж газрын хоолой барих ажлыг эхлүүлнэ гэж хамгийн өөдрөгөөр. Эхэлснээс хойш энэ 5800 км хоолойг барьж байгуулахад хамгийн багадаа 54 сар хэрэгтэй юм гэнэ. 4 жил хагас гэсэн үг.

Тэгэхээр бид нар бол яг газтай бүрэн хямдхан газтай болох хугацаа бол 29 оны төгсгөлөөс нааш бүтэхгүй нь. 29 он хүртэл амьдрал явах хэрэгтэй. Дулааны болон цахилгааны хэрэглээ нэмэгдэж байгаа учраас бид нар энэ төслийг оруулж ирсэн. Хүндрэлтэй байгааг та бүхэн ойлгож байгаа. Тариф дээрээсээ зохицуулалттай, зардал зах зээлийн замаар гардаг учраас ийм байна.

Тэгэхээр Улаанбаатар хотод бол бид нар 1.5 мегаваттын хүчин чадалтай дулааны хувьд гэж тавьсан юм. Ямар бодлого бариад байна вэ гэвэл Эрчим хүчний яам ойролцоогоор 200 айлын яндаг нийлүүлээд 1 дулааны станц руу байлгая гэж ийм бодлого барьж байгаа. Яагаад 1.5-ыг барьсан юм гэхээр Монгол Улс нэгдмэл улс. Сумын төв дээр байх дулааны станцын хамгийн доод хэмжээ нь 1.5 мегаватт учраас хот, хөдөөгөөр нь ялгах бололцоогүй байгаа учраас ийм тооцоо хийсэн шүү.

Харин зүгээр нүүрсний хувьд юу вэ гэхлээр одоо бид нар энэ Улаанбаатар хотод нэг ахиц хийсэн. Урьд нь Багануурын нүүрс түлж байсан. Одоо Эрдэнэс Тавантолгой ER-ийн мидлингээр хийж байгаа. Дэгдэмхий 22 хувьтай байгаа. Энэ ондоо багтаагаад бид нар хагас коксын үйлдвэрийг Багануур дээр барихаар судалгаа хийгээд Засгийн газрын холбогдох шийдвэрийг гаргуулахаар явж байна. Тэгсэн тохиолдолд дэгдэмхий 12-оос доошоо бууж ирнэ. Багануурын нүүрс дээр энэ энэ тоо 42-46 байгаа гээд ингээд нүүрс түлсэн тохиолдолд бол огт утаагүй болохгүй. Утааны хэмжээг дахин дахин багасгах тухай л ярьж байгаа бодит

байдал энэ. Энийг бас Өнөрболор гишүүн ойлгооч.

Тэгэхгүй бол бид нар энэ ард түмэнд чинь худлаа ярьсаар байгаад, буруу хүлээлт үүсгэсээр байгаад, худлаа ярьсаар байгаад ийм байна.

Хоёрдугаарт энэ 300 айлыг нэгтгээд 1 дулааны станц руу оруулах юм бол агаар мандалд цацруулах хорт хийн хэмжээ 10 дахин бууна. 200 яндан тус тусдаа гаргах юм уу, эсвэл 1 дулааны станц болгоод тэр станц дээр нь шүүлтүүр тавьсан тохиолдолд 10 дахин буурах тухай л ярина. Огт утаагүй болох тухай асуудал байхгүй, дийлэхгүй. Энийг бас гишүүд минь ойлгооч л гэж хүсэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Тэмүүлэн даргаа энэ асуудлыг байна шүү дээ маш тодорхой болгосмоор байна. Тухайлах юм бол хэрэв зарчмын зөрүүтэй санал наад дээр чинь болдоггүй юм гээд тэгэх юм бол энэ хуулийг тэр чигээр нь та нар өөрсдөө болиоч ээ. Энийг гишүүдийг бол дэмжихгүй байхыг, дэмжихгүй байна. Яагаад үгүй ээ энэ дэмжихгүй байгаа нэг асуудлын хувьд гээд тэгэх юм бол өнөөдөр та нар шинжлэх ухаанчаар хандах хэрэгтэй.

Дээрээс нь хот, хөдөөгийн ер нь Чойжилсүрэн сайдаа ичих хэрэгтэй. Эрчим хүчний яам өнөөдөр нүүрс рүүгээ буцаад шилжиж байна өөр арга байхгүй байна гэж ярихаасаа ичих хэрэгтэй.

Дээрээс нь гээд тэгэх юм бол үндсэндээ энэ ард иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ингэж хязгаарлаж, ингэж боомилж болохгүй. Нэн ялангуяа хотод бол, манай Сэлэнгэд ч гэсэн өнөөдөр 50 мегаваттын энэ дулааны станц хэрэгтэй байгаа юу хэрэгтэй байгаа. Би тэрийг бол дэмжиж байгаа юм. Хотод бол өнөөдөр ялгамжтай байхгүй бол болохгүй нөхцөл байдал байгаа юм. Та нар ч яах вэ

өнөөдөр бид нарын өөдөөс хараад, миний өөдөөс хараад инээгээд ингээд ичихгүй ингээд юу яаж л байна л даа. Тэгээд яах вэ өнөөдөр намар ямар нөхцөл байдал үүсэх вэ гэдгийг бол та нар яг газар дээр нь харчхаад, тэгээд энэ инээдэм байна уу, ханиадам байна уу гэдгийг бол харах байх.

Би яагаад ингэж их эсэргүүцээд байгаа вэ гээд тэгэхлээр энийг та нар арай жаахан шинжлэх ухаанчаар ч гэсэн ийм ялгамжтай байдлаар судалгаагаар сайн хийгээд энэ хуулийг бас ахиад дахин оруулж ирж болно шүү дээ. Яагаад болохгүй гэж. Заавал яг ингээд бүгдээрэнд нь том, жижиг зүйлийг нэг дор бүгдээрэнг нь шавааралдуулаад тэгээд өнөөдөр ингээд нүүрс рүүгээ буцаж байгаа энэ бодлогоосоо ухарч байгаа энэ бодлогоо ингээд янз бүрийн байдлаар ингээд хамгаалаад байгаад байна гэдэг чинь бол байж болохгүй зүйл шүү дээ.

Нэг гараараа та нар нийслэлийн хүн амын амьдралын чанарыг бууруулах, агаарын бохирдлыг бууруулах асуудал дээр өчнөөн мөнгө төгрөг гаргачхаад, нөгөө талаараа гээд тэгэх юм бол та нар яаж байна. Буцаад л нүүрс рүүгээ шилжих ийм л ичгүүртэй зүйлийг ярьж байна шүү дээ. Эрчим хүчний яам танд сайд болсон бол.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Чойжоо гишүүн.

Б.Чойжилсүрэн: Өнөрболор гишүүнээ тантай маргах ямар ч сонирхол байхгүй. Бодит байдлаар ойлгоцгооё л гэж байгаа юм. Та өөрөө өөртэйгөө зөрчилдөөд байна шүү дээ. Сэлэнгэд 50 мегаваттын цахилгаан станц барина гээд нүүрс түлнэ, тэрийг чинь дэмжих гэж байгаа юм. Танд одоо энийг энэ хуулийн төслийг унагачхаад танд дундаа санал байвал дэмжихэд бэлэн байна. Бид тийм, Эрчим хүчний яам заавал бидний зөв гэж мухарлаад зүтгээд байхгүй. Саналаа хэлчих, гаргалгаагаа хэлчих.

Г.Тэмүүлэн: Болноо одоо. Би хангалттай та бүхэнд тайлбар хэлсэн байх. Би, Өнөрболор гишүүнээ би таны гаргасан зарчмын зөрүүтэй саналыг эхлээд танилцуулаадахъя.

Саналын томъёолол нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн дараа гэж байгаа юм. Тайлбар энэ хуулийн үйлдвэрлэх гэдэгт нийслэл Улаанбаатар хотод түүхий нүүрс болон стандартын шаардлага хангаагүй түлшийг ашиглах тохиолдолд энэ заалт хамаарахгүй гэж нэмэх гээд энэ саналыг гаргасан байгаад байгаа юм. 1 дүгээр зүйл гэдэг маань өөрөө юу байгаа юм бэ гэхээр ерөнхийдөө бол 1 дүгээр зүйл Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд дор дурдсан агуулга бүхий 22.5.14 дэх заалт нэмсүгэй гээд. Тэгээд 1/22 дугаар зүйлийн 22.5.14 дэх заалт нь цахилгаан эрчим хүчний 5 мегаваттаас дээш хүчин чадалтай, эсхүл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 9 хувь хөнгөлнө гэсэн ийм л нэг заалт байгаад байгаа юм.

Тэгэхээр яг Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиараа хуульд өөрчлөлт оруулах буюу энэ бол нэг талдаа Засгийн газраас гаргаж байгаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах заалт болж таарч байгаа юм. Тэгэхээр энэ хуульд өөрчлөлт оруулах энэ хуулийн төслийг хэлэлцэхдээ саяын би танд түрүүн хэлсэн 40.3.7 дээр хуулийн төслийн заалтын үг, өгүүлбэрийн дараа бие даасан агуулга бүхий үг, өгүүлбэр нэмэхийг хориглоно гээд заачихсан байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ заалт бол яг үндсэндээ нэг талдаа агуулга нь өөр агуулга нэмж байгаа бие даасан агуулга өгүүлбэр, үг нэмж байгаа заалт учраас

энэ хураалгах бол боломжгүй болчихоод байна гэдгийг танд бас учирлаж хэлж байна.

Тэгэхээр хувь хүнийхээ үүднээс, Байнгын хорооны даргын хувьд Байнгын хорооны хуралдааныг Улсын Их Хурлын дэгийн хуулийн тухай явуулах үндсэн үүрэгтэй байгаа гэдгийг танд хэлэх байна.

Эсвэл та бүүр горимын санал гаргаад хууль санаачлагчид нь буцаах тийм санал гаргаж болно нэг талдаа. Дэгийн хуулиар. Тэрүүгээр санал хураалгаж болно тэгээд цаашаагаа явж болно гэсэн үг. Та тэгвэл горимын санал гаргах уу? Өнөрболор гишүүн Өнөрболор гишүүн горимын санал гаргах уу та тэгвэл? Та горимын санал гаргах уу тэгвэл? Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Тийм, би сая энэ Чойжилсүрэн сайд тайлбарлахдаа бас буруу тайлбарлаад байна л даа. Би өнөөдөр Сэлэнгэ аймагт ч гэсэн хэрэгцээтэй байгаа бодлогын том агуулгаар нь бол дэмжиж байгаа. Гэхдээ хот, хөдөөгийн хувьд гээд тэгэх юм бол ялгамжтай, шинжлэх ухаанчаар хандсан судалгаатай ялгамжтай хууль оруулж ирээч л гэдэг асуудлыг яриад байгаа юм. Энэ юу нь болохгүй байгаа асуудал байгаад байгаа юм бэ. Та нар энэ том “Шинэ сэргэлтийн бодлого”-ын асуудлын ард өнөөдөр иргэдийн аюул, эрүүл орчинд амьдрах энэ эрхийг боогдуулах, Агаарын бохирдлын бууруулах үндэсний хорооноос авч хэрэгжүүлсэн шат шатад авч хэрэгжүүлсэн энэ бодлогын эсрэг Эрчим хүчний яам эсрэг бодлого баримталж байна шүү дээ. Ухарч байна шүү дээ та нар. Ингэж болохгүй шүү дээ. Тэгвэл бүр бүхэлд нь энэ хуулийг буцаагаад шинжлэх ухаанчаар, би дахиад хэлье ахиад судалгаатай, хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар энэ хуулиа оруулж ирээч ээ. Би тийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Тийм, тэгээд манай гишүүд энэ дээр дэмжиж өгөөч гэж би та бүгдээс хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн тэгэхээр горимын санал гаргаж байна. Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаая гэсэн горимын санал гаргаж байна гэж ойлгох уу? Өнөрболор гишүүнээ Өнөрболор гишүүнээ хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаая гэсэн горимын саналыг гаргаж байна гэж ойлгож байна тээ. За.

Горимын саналаараа санал хураалтыг явуулъя. Өнөрболор гишүүн горимын санал гаргалаа. Санал хураалт.

Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаая гэсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулж байгаа юм байна.

Санал хураалтад 27.3 хувиар дэмжигдсэнгүй.

Ингээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, санал гаргаж дууслаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Санал хураалтыг явуулж дууслаа.

Улсын Их Хурлын, ингээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж, хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргасан дүгнэлтийг Чойжилсүрэн сайд та чуулганд танилцуулах уу? Амартүвшин гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна. Гурав дахь асуудалдаа оръё.

10.52 цаг

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүн танилцуулснаар адилхан байна. Ингээд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Санал хураалт явуулж дууслаа.

Ингээд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж, хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Ажлын хэсэгт баярлалаа. Дөрөв дэх асуудалдаа орёё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Ингээд Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаад байгаа.

Цэцийн хуралдаанд итгэмжилсэн төлөөлөгчөөр бас миний бие оролцсон. Ингээд та бүхэнд товч танилцуулга, мэдээллийг хийе.

2023 оны 06 сарын 16-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтээр ерөнхийдөө Монгол Улсын иргэн Цолмонбат, Энхтүвшин, Эрдэнэцэцэг нар бас Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасан байгаад байгаа. Цэцэд гомдол гаргасан үндэслэл нь Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 4, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэдэг энэ гомдлыг гаргасан байсан.

Ингээд Цэц энэ иргэдээс гаргасан мэдээлэл дээр үндэслэж маргааныг 06 дугаар сарын 16-ныхаа хуралдаанаар хэлэлцээд ингээд тухайн тэр гаргасан шийдвэр дээрээ бол төрийн санхүү, зээл, татвар, мөнгөний бодлого нь иргэдийн амьжиргаа, эдийн засаг, үйлдвэрлэл зэрэгт шууд нөлөөлдгийг харгалзан шинээр татвар тогтоох, эсвэл өөрчлөхдөө хууль тогтоогч холбогдох тооцоо, судалгаанд үндэслэхийн зэрэгцээ төрийн бусад бодлоготой уялдуулах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцүүлэх ёстой гэсэн. Энийг үндэслэж Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох судалгаа, бүрдүүлбэрийн хамт өргөн мэдүүлсэн байх боловч дүгнэлт, судалгаа нь иж бүрэн бус, бодит байдалд нийцээгүй гэсэн дүгнэлтийг бол гаргасан байгаад байгаа. Үндэслэлээр хийсэн байгаа.

Түүнчлэн тухайн хуулиар зохицуулах харилцаанд оролцогчид бол эрх зүйн байдал болон улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх асуудлыг бол тусгаагүй байна гэсэн үндэслэлийг хийсэн байсан.

Мөн дээр нь хоёр дахь асуудал нь Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан гэж үзэхээр байна гэсэн. Энийг бол илэрхийлсэн байгаа. Үүн дотроо бол төрийн үйл ажиллагааны энэ албан татварыг шатлалгүйгээр тогтоосон төрийн үйл ажиллагааны тэгш байдлын зарчмыг зөрчиж, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал болоод аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулахаар заасанд нийцэхгүй байна гэсэн.

Энэ дээр үндэслээд ингээд Онцгой албан татварын тухай хуулийн маргаан бүхий заалтууд нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн холбогдох заалтыг бол тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна гэсэн энэ дүгнэлтийг бол хийсэн байгаа.

Хоёрт. Харин Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн шударга ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэснийг бол зөрчөөгүй байна гэсэн энэ дүгнэлтийг гаргасан байгаа.

Ингээд энэ Онцгой албан татварын тухай хуулийн энэ 3 заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 23 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй гэсэн дүгнэлтийг бол Үндсэн хуулийн цэц гаргасан байна.

Хуралдааныг даргалсан Туулхүү, гишүүд нь Солонго, Буяндэлгэр,

Баясгалан, Эрдэнэбулган гэсэн нарын бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан байна.

Ингээд Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлттэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Батжаргал, Амартүвшин гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ бол, нэг зүйлийг л би та нарт хэлье. Ямар ч үйлдвэр байхгүй шүү. Ямар ч үйлдвэргүй мөртөө ид үедээ 2020 онд 230 мянган тонн керосин, нафта гээд хольцыг оруулж ирж байгаад тэгээд тэр шатахууныхаа савны 75 хувьд нь оригинал дизелийн түлш хийчхээд, үлдсэн 25 хувьд нь керосиныг хийгээд, доор нь нэг ийм сэнс л эргүүлдэг байхгүй юу даа. Тэгээд тэр эргүүлсэн тэр савнаас нь дизелийн түлш ч юм уу ачаад Төв аймгийн Архуст сум дээр очоод буудаг. Буунгуут тэр колонкийн доод талд нь сэнс байх юм биш, доошоо хүнд металл нь унаад, дээр нь дээрээ хөнгөн металл нь үлдчихдэг. Тэрнээсээ болоод бүх хүмүүсийн машин тэрэг бүгдийг нь эвдэж байгаа. Тийм энэ бол дээд зэргийн хууль бус бизнес. Стандартын бус. Энэ дэлхийн бүх орноос хөөгдөөд Монголд ирсэн. Монгол бол энэ ийм хог новшийн оршуулгын газар биш гэдгийг би хэлье.

Тэгээд энэ дээр бол авлигал нэвт үнэртдэг бузрын бизнес. Тэр хүнд металлаар нь явсан машинууд замын хажуу талын гэрлэн шонгийн доод тал тэр чигээрээ хар байдаг байсан сүүлийн 2 жил байхгүй болсон шүү дээ. Бидний алаг үрс л тэрийг хорт утаагаар, хорт металлаар амьсгалж, тэгээд ерөөсөө ямар ч эмгэгүүд илаарьшидаггүй тэр бүх зүйл чинь энэнээс л болдог.

Тэгээд энийг ингээд ер нь бол ямар их аймаар сүлжээтэй юм бэ. Хүн болгоныг худалдаж авч чадахгүй л дээ. Тэгээд энэ Оросуудын нөлөөгөөр Оросуудын хуурамч шатахууныг одоо энэ Монголчуудаа хамгаалсныхаа төлөө

Оросуудын нөлөө Оросуудын нөлөө энд ерөөсөө байхгүй.

Харин Оросууд энийг хийж байгаа. Эсэргүүцэнийхээ төлөө Оросын нөлөөнд орлоо гэж байгаа. Оросууд харин энийг хийж байгаа байхгүй юу. Швейцарын иргэншилтэй 2, 3 Орос байдаг юм. Тэгээд бид нарыг хордуулж, бид нарын машин тэргийг эвдчихээд Сингапурт амьдардаг. Тэгээд орж ирсэн мөнгө нь бүгдээрээ валют болоод гараад явчихдаг. Бид нарыг, тэгээд 100-гаад тэрбум төгрөгийн татварын орлого улсын төсвөөс сох дутдаг ийм л юм байгаа.

Энэ үйлдвэр бол Монголчуудын ирээдүйн эрх ашгийн эсрэг байгаа. Өөрөөр хэлбэл Алтан ширээд баригдаж байгаа нефтийн үйлдвэр блок болно. Ажиллахгүй. Бид нар нэг аравны хэдэн тэрбум бараг 6, 7 тэрбумаар тэр үйлдвэрээ барих байх.

Тэгээд бид нар тэр ажилладаггүй үйлдвэрийг үйлдвэр болгож хувирна. Энийг зөвшөөрсний үндсэн дээр. Бүх юм нь Монголчуудын эсрэг юман дээр хуруугаа дараад л байх юм даа, кнопоо дараад байх юм даа. Ямар муухай юм бэ, ямар увайгүй юм бэ. Өчигдрийн тэр Хууль зүйн байнгын хорооны тэр дарга. Бүгдээрээ ёстой болохгүй болохгүй гэж байж яг кноп дарах болсон чинь бүгдээрээ дэмжчихсэн дарж явна лээ шүү дээ. Ийм ч ёстой ямар ч увайгүй, ямар ч ийм муухай. Би нотлоод өгнө. Одоо яах вэ 3 000 тонн хуурамч шатахууны хольц аль хэдийн ирчихсэн энэ Чойр дээр зогсож байгаа. Би өдөржингөө тэр видео бичлэг хийлгэнэ. Яаж хольдог юм. Тэнд ямар үйлдвэр байгаа юм бэ. Ямар ч үйлдвэр байхгүй байна шүү дээ. Юун үйлдвэрлэлийг дэмжих гээд донгосоод байгаа юм бэ. Цэцийн тэр хэдэн нөхдүүд бүгдээрээ тэр нэг хуралдаанд орсон нөхдүүд нь ихэнх нь асуудалтай нөхдүүд шүү дээ.

Тэгээд ингээд тэтгэвэртээ гарах гэж байгаа тэр нөхдүүд бүгдээрээ ингээд

л энэ юу ч хийсэн хамаагүй, одоо сүүлдээ ингээд бүүр ийм заваан юмны юманд оролцоод л тэгээд л ингээд будилуулаад явж байна. Мэдээж Монголын ард түмэн харж байгаа.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр энэ хуурамч шатахууны тухай яриад байгаа юм. Тэгэхдээ шатахуунд холигддог хольцын тухай л юм л даа. Ер нь бол яг нарийндаа тэгж л ойлгогдоод байх шиг байна гэж.

Үнэхээрийн эдийн засаг, энэ иргэдийн аж амьдрал, энэ тээврийн хэрэгсэл, байгаль орчин, агаар мандал энэ бүх юманд сөрөг нөлөөтэй юм байна гээд бид шийдвэр гаргасан. Гаргасан шийдвэрийг маань тодорхой хүмүүс гомдол, мэдээлэл гаргаад Цэц дээр очоод тодорхой заалтуудыг нь хүчингүй болгож байгаа юм байна гэж.

Тэгэхээр үүнийг бид нэлээн ул суурьтай судалж, зөв мэдээлэл, дүгнэлттэй болох ёстой. Тийм учраас энэ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам энэ газрын тосны асуудлаа хариуцсан нөхдүүд тэр бүхэл бүтэн тэр шинжээчид энэ тэрээ татаж оролцуулж үүнийгээ нэг мөр нэг талд нь гаргасан том дүгнэлтээ гаргаж өгмөөр байна.

Тэгж байж энэ хууль тогтоох байгууллага үнэн, бодитой шийдвэр юмнуудаа гаргаж үндэснийхээ эрх ашиг энэ юманд нийцсэн шийдлээ гаргах ёстой.

Тийм учраас би бол энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудлыг хойшлуулах ёстой гэсэн ийм бодолтой байна. Шийдэл гаргамааргүй. Тэр холбогдох асуудал хариуцсан нөхдүүд нь үүнтэй яг бодитой, тов тодорхой ийм дүгнэлт юмнуудаа гаргаж ирүүлэх шаардлагатай байна. Ингэж асуудалд янз бүрийн байдлаар хандамгүй байна.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. Яах вэ би бол гол нь манай жижиг эдийн засгийн бизнес орчныг л бид нар аль болохоор дэмжих ёстой л гэсэн байр суурьтай байдаг.

Тийм болохоор энэ Татварын хуулиар аль нэг талд нь давуу байдал үүсгэж ингэж өрсөлдөөнийг боомлох нь бол буруу гэж, зарчмын хувьд бол буруу гэж үзэж байгаа.

Өөрөөр хэлбэл яг ний нуугүй ярихад бол манай зарим гишүүд чинь бол түлшний бизнес эрхэлдэг хүмүүс шүү дээ. Тэд нар бол нэлээн тийм сайн лоббитой. Гол өрсөлдөгчтэй, өрсөлдөгч компани нь нийлүүлэгчээ бас намнах тийм л үйл ажиллагаа явуулсан л гэж би хараад байгаа юм.

Харин үнэхээр тэр түли, тэр хольж хольсон түли нь тийм муу чанартай, эрүүл мэндэд аюултай гэж байсан энэ чинь стандарт, стандарт зохицуулалтаараа л явах ёстой биз дээ. Одоо тэр экспертүүд нь ирээд л тэр түли нь зөв байна уу, буруу байна уу, үйлдвэрлэлийн процесс нь байна уу, байхгүй байна уу, стандарт нь нийцэж байна уу, үгүй гэдгийг л гаргах, гаргаад л тэр дүгнэлтийнхээ үндсэн дээр тийм үйл ажиллагаа явуулах эсэхийн л зөвшөөрлийн л асуудал болчхож байгаа юм биш үү.

Тийм болохоор би бол энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авсан нь зөв гэж бодож байгаа. Яагаад өөр бусад гишүүдийн яриад байгаа тэр болгоомжлолыг бол би сайн ойлгож байна. Гэхдээ тэрийг бол ийм татварын хуулиар шийдэх ёстой гэж би үзэхгүй байгаа.

Тийм болохоор энэ Цэцийн шийдвэрийг бол хүлээж аваад, харин тэр салбар яам болон тэр хяналтын байгууллагууд нь хяналтаа тавиад,

стандартаа тогтоогоод тэрийг мөрддөг байх л хэрэгтэй л гэж бодож байгаа.

Г.Тэмүүлэн: Асуулт асууж дууслаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу. Кнопоо дараарай. Пүрэвдорж гишүүн горимын санал гаргана гэж байгаа. Пүрэвдорж гишүүн, микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Би Батжаргал гишүүнтэй бас санал нэг байна. Тэгэхээр ер нь бол энэ чинь Цэцийн дүгнэлт, одоо энэ яаж хийж байгаа процедурыг нь мэргэжилтнээс асуухгүйгээр тэгээд шууд ингээд явчхаж байгаа нь ерөөсөө боломжгүй байна л даа.

Тийм учраас мэргэжлийн хүмүүсийг суулгаж энэ Байнгын хороон дээр яаж хийдэг юм. Одоо жишээ нь цагдаагийн байгууллага, АТГ ч юм уу очоод тэнд Чойр дээр үйлдвэр байна уу очоод шалгаад ирмээр байна. Яг ингээд тос болоод хольдог тийм ээ. Тэгээд яг тэр бензин шатахууныг яг стандартын дагуу хийж байгаа тийм үйлдвэр байна уу. Байвал энэ үйлдвэр байна гээд энэ зургийг нь үзүүлчихмээр байна. Та нар очих завгүй бол тийм ээ. Үйлдвэрийг нь үзүүлчихмээр байна. Үйлдвэрлэлээ дэмжинэ гээд байх юм. Зарим гишүүд үг хэлэхээрээ тийм үг нь эвлэж өгөхгүй байгаа биз. Энэ чинь ийм шударга бус юман дээр чинь хүний үг эвлэдэггүй байхгүй юу даа. Аймаар айдастай үг хэлдэг. Дараа нь хэл аманд орчих вий гэдэг айдастай. Тэгээд энэ мэргэжилтнүүдийг оролцуулж бас тодорхой хэмжээний мэдээллийг авах, яг энэ үйлдвэр байгаа юм уу, байхгүй юм уу.

Тэгээд тэр гишүүн, зарим нэг эсэргүүцээд байгаа гишүүдийн тэр нөгөө 200 Lexis энэ тэрд нь тэр бензинийг нь хийгээд бас сайхан хөдөө явуулаад эвдрэх нь үү, доголдох нь уу сайхан үзээд ингээд яамаар байна.

Тийм учраас бүлгийн даргыг эзгүйд орлох хүн энэ асуудлаар завсарлага авах эрхтэй. Тэгэхээр энийг

заавал дэд дарга гэж ойлгохгүй байна. Өөрөөр хэлбэл би хэд хэдэн удаа, өөрөөр хэлбэл тухайн асуудлаар орлох боломжтой гэж. Өөрөөр хэлбэл энэ хууль бол миний өргөн барьсан хууль. Тийм учраас энэ дээрээ би энэ орлож завсарлага авах бүрэн эрхтэй гэж үзэж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

Тийм учраас ажлын 5 хоногийн завсарлагаа хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн ажлын 5 хоног завсарлага авах санал гаргаж байна. Завсарлага авах горимын санал гаргаж байна.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиараа Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор гэсэн хугацаатай байгаад байгаа. Тэгэхээр чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор гээд Хууль зүйн байнгын хороо болоод холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөх эсэх талаар санал, дүгнэлт гаргана гэсэн байгаад байгаа юм.

Тэгэхээр, тэгэхээр энэд Дэгийн тухай хуулийн 82.2.1-ээр хүлээн авснаас хойш Байнгын хороо бол 5 хоногийн дотор гэсэн ийм хугацаатай байгаад байгаа юм. Тэгэхээр би зүгээр Байнгын хороо даргалагчийн хувиар таны гаргасан саналыг, мөн Батжаргал даргын санал ч гэсэн бас тийм агуулгатай байгаа учраас маргааш өглөө болтол 9 цаг хүртэл 1 хоногийн завсарлага бас өгөх шийдвэр гаргаж байна. 1 хоногоор завсарлагыг хүлээн авлаа. Маргааш өглөө 9 цаг хүртэл.

Ингээд 1 хоногийн завсарлага авсан тул өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаан хаасныг мэдэгдэж байна. Маргааш хүртэл. Баярлалаа.

11.11 цаг